

ТАНИЛЦУУЛГА, ТОО  
БАРИМТ

**АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС  
НУТГИЙН ОЛОН УЛСЫН  
БАЙГУУЛЛАГУУДЫН ТАЛААР  
ТОВЧХОН**

**Ц. Эрдэнэчимэг\***

XX зууны хоёрдугаар хагаст дэлхийн улс төр, эдийн засгийн дүр зурагт асар их өөрчлөлт гарсан билээ. Дэлхийн колонийн систем задран унаж, Ази, Африк, Латин Америкийн урьдын хоцрогдсон хараат олон орон эрх чөлөө, тусгаар тогтнолыг олж, эдийн засгийн хөгжлийн замд орсон юм.

Эдүгээ дэлхийн улс төр, эдийн засгийн амьдралд Ази, Номхон далайн бүс нутаг чухал үүрэг гүйцэтгэх болов. Энэ бүс нутгийн томоохон улсын нэг болох Япон сүүлийн жилүүдэд техник, технологийн хөгжлийн оргилд гарч, 40-өөдхөн жилийн тэртээ хоцрогдмол, ядуу байсан Сингапур, Тайланд, Өмнөд Солонгос зэрэг орнууд Азийн «бар» болж, олон улсын эдийн засгийн хөгжилд дээгүүр байр суурь эзлэх болсон байна. Азийн том гүрэн-БНХАУ эдийн засгийн нээлттэй бодлого хэрэгжүүлсний дүнд ахар богино хугацаанд аж ахуйгаа хөгжүүлэн дэлхийн аж үйлдвэрийн үйлдвэрлэлд хүндтэй байр эзлэх болжээ. Тус бүс нутгийн бусад улс орнууд ч түргэн хөгжиж дэлхийн төр-эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаанд гүйцэтгэх үүрэг нь өссөөр байна.

Сүүлийн үеийн байдлаар бүс нутгийн орнууд дэлхийн худалдааны эргэлтийн 50 гаруй хувийг эзэлж байна. Ази, Номхон далайн ард түмнүүдийн хөгжлийн асуудлыг тус бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлаас салангид авч үзэж болохгүй юм. Бүс нутагт энх тайван, тогтвортой байдал бат бэх байх явдал бүс нутгийн ард түмнүүд улс орноо улам цэцэглэн хөгжүүлэхийн баталгаа болно. Тус бүс нутгийн орнуудын энх тайван хөгжил, эдийн засгийн бие даасан байдлыг найдвартай хангах гол хүчин зүйл нь харилцан ашигтай хамтын ажиллагаа юм. Улс төр-эдийн засгийн хамтын ажиллагаа нь Азийн орнуудын байгалийн асар их баялаг, хөдөлмөрийн их нөөцийг зохистой ашиглаж дэлхий нийтийн хөгжил дэвшлийг түргэтгэхэд их үүрэгтэй юм.

Улс орнуудын хамтын ажиллагаа, нэн ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагааны ач холбогдлыг Ази, Номхон далайн орнууд, дэлхийн бусад бүс нутгийн улс орнуудтай нэгэн адил ухамсарлан, хамтын ажиллагааны олон арга хэлбэрийг хөгжүүлэн хэрэгжүүлж байна. Тэрхүү арга хэлбэрийн дотор бүс нутагт тусгайлан байгуулагдсан улс төр-эдийн засгийн болоод эдийн засгийн байгууллагууд онцгой ач холбогдолтой. Эдгээр байгууллагууд нь бүс нутгийн орнуудын эдийн засгийн хөгжлийг хангах, интеграцчиллыг хөгжүүлэх, тэдгээрийн хооронд болон бусад тив, бүс нутгийн орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой бөгөөд тэдгээрийн дотор Засгийн газрын ч, Засгийн газрын бус ч байгууллага байна.

Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын байгууллага олон байдаг боловч манай улсын улс төр, эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс авч үзэхэд хэд хэдэн томоохон байгууллага, ялангуяа эдийн засгийн байгууллага сонирхол татаж болох юм.

Тэдгээрийн дотор томоохон нь Ази, Номхон далайн бүс нутгийн Эдийн засаг, нийгмийн комисс (Economic and Social Commission for Asia and the Pacific) юм. Энэ Комисс 1947 онд Ази, Алс Дорнодын Эдийн засгийн комисс нэртэйгээр дайнд сүйдсэн Ази, Алс Дорнодын

\* Ц. Эрдэнэчимэг — Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

орнуудын эдийн засгийг сэргээхэд тусламж үзүүлэх зорилготой байгуулагджээ. Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комисс (1951 оноос ингэж нэрлэгдэх болсон) нь бүс нутгийн орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийг иж бүрэн хангах, байгалийн нөөц, баялгийг ашиглах, хөгжлийн программыг зохицуулах, бичиг үл мэдэх явдлыг устгах, орон сууц барих зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх зорилготой Засгийн газар хоорондын байгууллага ажээ. Комиссын дээд байгууллага нь жилд 1 удаа хуралддаг өргөтгөсөн чуулган бөгөөд чуулганаар бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилтэй холбогдолтой бүх асуудал, тухайлбал гишүүн орнуудад санхүүгийн зээл, тусламж үзүүлэх асуудлаар шийдвэр гаргадаг байна. Комиссын бүрэлдэхүүнд: нийгмийн хөгжлийн төлөвлөлт; үйлдвэрлэл, технологи, байгалийн нөөц; хүн амын байршил; статистик; худалдаа, хөлөг онгоцны үйлдвэрлэл; тээвэр холбоо зэрэг асуудлуудыг эрхэлдэг 9 хороо ажилладаг байна.

Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс НҮБ-ын системийн бусад олон улсын байгууллагууд, тухайлбал НҮБ-ын Хөгжлийн Программ (UNDP), НҮБ-ын Хүн амын байршиллын фонд (UNFPA), Олон улсын хөдөлмөрийн холбоо (IZO), НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага (UNIDO), НҮБ-ын Хүнс тэжээл, хөдөө аж ахуйн байгууллага (FAO), НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO), Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD)-тай нягт хамтран ажиллаж, тэдний тус дэмжлэгийг ч нэлээд авдаг байна.

Эдийн засаг, нийгмийн комиссын үйл ажиллагааны чиглэл, зорилгоос ч харахад энэ байгууллага тус бүс нутгийн орнуудын эдийн засаг, нийгмийн салбаруудыг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг болох нь тодорхой байна. Комиссын туслалцаа дэмжлэгтэйгээр бүс нутгийн орнуудад, тухайлбал Индонези, Малайзи, Сингапур, Филиппинд олон сайхан зам гүүр, үйлдвэрийн томоохон газар болон орон сууц, эмнэлэг баригдаж, улс ардын аж ахуйн олон чиглэлээр боловсон хүчин бэлтгэгджээ.

Комисс өөрөө ийнхүү бүс нутгийн орнуудын хөгжилд нөлөөлөхөөс гадна түүнээс салбарлаж гарсан тодорхой чиглэл бүхий байгууллагууд мөн их үүрэгтэй юм. Тэдгээрээс манай орны хувьд сонирхолтой байж болох заримаас дурдъя.

1977 онд Энэтхэгийн Банголор хотноо байгуулагдсан Бүсийн технологи дамжуулах төв (Regional centre for technology transfer) нь эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн орнуудын хооронд шинэ технологийн мэдээ солилцох хийгээд хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой юм. Тэрээр гишүүн орнуудыг шаардлагатай технологиор хангах, технологийг сонгоход туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ бүс нутгийн орнуудад технологийн үндэсний төв байгуулахад туслагчаар оролцдог байна. Нэг үгээр хэлбэл энэ төв нь бүс нутгийн орнуудын шинжлэх ухаан, техникийн хөгжлийг хангахад нэлээдгүй хувь нэмэр оруулдаг байна.

Бүсийн технологи дамжуулах төв нь үндэсний Засгийн газрууд болон НҮБ-ын системийн олон улсын зарим байгууллагууд, тухайлбал Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага, Хөгжлийн Программ, бүс нутгийн Эдийн засаг, нийгмийн комисстой нягт хамтран ажилладаг байна. Тэд хамтран нийгмийн амьдралд шинжлэх ухаан, техникийн нөлөөлөх нөлөө зэрэг асуудлуудаар олон улсын семинар, уулзалтыг зохион байгуулдаг.

Ази, Номхон далайн худалдаа, хөгжлийн асуудлаархи бага хурал (Conference on trade and development for Asia and the Pacific) нь 1978 оны 8 дугаар сард Шинэ Делид хуралдаж, бүс нутгийн орнуудын хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хө-

төлбөр боловсруулсныг Эдийн засаг, нийгмийн комисс 1979 онд баталжээ. Энэ хурлаас худалдааны асуудлыг зохицуулах бүлэг байгуулсан бөгөөд тэр нь хамтарч худалдаа хийх дэд бүлэг, худалдааны удаан хугацааны гэрээ, хэлэлцээрүүд байгуулах дэд бүлэг, бараа таваарын асуудал хариуцсан дэд бүлэг, санхүү-зээлийн асуудал эрхлэх дэд бүлэг, бүс нутгийн хэмжээнд хийх худалдааг хөхүүлэн дэмжих, хөнгөлөлт үзүүлэх асуудал эрхэлсэн дэд бүлэг, худалдааны статистикийн мэдээ, гаалийн норм, норматив, тарифын баримт бичгүүдийг боловсронгуй болгох асуудал эрхэлсэн дэд бүлгээс бүрдэж, бүс нутгийн орнуудын хооронд худалдааны салбарт явуулах хамтын ажиллагааг боловсронгуй болгох зорилготой юм.

Энэхүү бүлгийн үйл ажиллагаанд 21 улс оролцдог бөгөөд тэд худалдааны нэлээд хөнгөлөлтийг эдэлдэг бололтой.

Азийн бүс нутаг дахь эрдсийн нөөцийн хамтарсан судалгааны ажлыг зохицуулах хороо (Committee for co-ordination of joint prospecting for mineral resources in Asia offshore arease) нь 1966 онд байгуулагдсан Засгийн газар хоорондын байгууллага юм. Азийн нутагт нефть, эрдсийн нөөцийг нэмэгдүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилготой. Тодорхой асуудлуудаар судалгааны программ боловсруулж, санхүүжүүлэн хэрэгжүүлэхийн хамт энэ салбарын мэргэжилтэн бэлтгэх сургах, гишүүн орнуудын хооронд хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байна.

Дээрх байгууллагуудын зэрэгцээ Меконг мөрний сав газрыг судлах асуудлыг зохицуулах хороо, Номхон далайн өмнөд хэсэг дэх эрдсийн түүхий эдийг хамтран ашиглах хамтын ажиллагааны хороо, Хар салхи (Тайфун) судлах асуудал эрхэлсэн хороо, Халуун орны хуй салхи (циклон) судлах асуудал эрхэлсэн байгууллага, Номхон далайн Өмнөд хэсэгт зориулсан хөгжлийг судлах зөвлөл, Ази, Номхон далайн орнуудын кокосын нэгдэл, Халуун ногоо, каучук үйлдвэрлэгч орнуудын холбоо, Зүүн өмнөд Азийн цагаан тугалга олборлож боловсруулах асуудал эрхэлсэн төв зэрэг тусгай асуудал хариуцсан байгууллагууд байдаг байна.

Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комиссын дэргэд ажилладаг салбарласан байгууллагуудаас манай орны хувьд сонирхол татаж болохуйц буюу үйл ажиллагаанд нь оролцвол ашигтай байж болмоор сургалт, судалгааны шинж чанартай хэдэн институт байгаа юм. Энэ нь Ази, Номхон далайн Хөгжлийн институт, Статистикийн институт, Хөгжлийн захиргааны төв, Нийгмийн хөгжил, сайн сайхны төв, Эмэгтэйчүүд ба хөгжлийн төв юм.

Ази, Номхон далайн Хөгжлийн институт (Asian and Pacific development institute) 1964 онд байгуулагдсан. Тайландын нийслэл Бангкок байрладаг. Тэрээр Эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг судлах, төлөвлөх чиглэлээр сургалт явуулж, зөвлөлгөө өгдөг ажээ. Үүний зэрэгцээ үйлдвэрлэлийг хөгжүүлэх, техник, технологи, тоног төхөөрөмжийг зөв сонгох, улс орны хөгжлийг янз бүрийн шатанд төлөвлөхөөс эхлээд барилга, хүн ам зүй, байгаль орчин, эмэгтэйчүүд, эх нялхсын асуудал, эрүүлийг хамгаалах, бүс нутгийн хэмжээнд хамтын ажиллагаа хөгжүүлэх зэрэг бүх л асуудлаар зөвлөлгөө өгч, сургалт явуулдаг байна. Сургалтыг 6 сарын ерөнхий курс, 3 сарын мэргэжил дээшлүүлэх тусгай курс зохион байгуулах замаар явуулдаг. Институтийг НҮБ-ын Хөгжлийн Программ, Эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн орнуудын Засгийн газрууд санхүүжүүлдэг.

Ази, Номхон далайн Статистикийн институт (Statistical institute for

Asia and the Pacific) 1970 онд нээгдсэн бөгөөд Токиод байрладаг. Тус институт Эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн орнуудад нийгэм, эдийн засгийн салбаруудыг статистикийн албаар үйлчлэх тогтолцоог боловсронгуй болгох, статистикийн үндэсний албуудыг хөгжүүлэх, тэдгээрийн хооронд туршлага солилцуулах ажлыг зохион байгуулахад тус дөхөм болох зорилготой юм. Энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд урт, богино хугацааны сургалтын болон мэргэжил дээшлүүлэх курсийг зохион байгуулдаг байна.

Ази, Номхон далайн Хөгжлийн захиргааны төв (Asian and Pacific development administration centre) 1973 онд байгуулагдсан Куала-Лумпурт байрладаг. Тус бүс нутгийн орнуудын засаг захиргааны болон төрийн байгууллагуудын бүтэц, дотоод зохион байгуулалтыг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Төв нь энэ чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулахын зэрэгцээ уулзалт, семинар зохион байгуулж, төрийн болон засаг захиргааны байгууллагуудын ажилтнуудын курсийг зохион байгуулдаг байна. Мөн орнуудын хүсэлтээр засаг захиргааны аппаратыг зохион байгуулах тодорхой асуудлаар тэдэнд зөвлөлгөө өгдөг. Төв сургалт-судалгааны үндэсний төвүүдтэй ажлаа нягт уялдаатай явуулж, ямарваа оронд шинээр үндэсний төв байгуулах, сургалтын материал, хөтөлбөр боловсруулахад нь туслалцаа үзүүлж, нийгмийн хөгжлийн төлөвлөлт, менежментийн талаар бичсэн бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дүнг хэвлэдэг байна.

Ази, Номхон далайн Нийгмийн хөгжил сайн сайхны төв (Social welfare and development centre for Asia and the Pacific) 1976 оноос ажиллаж эхэлсэн. Манилд байрладаг. Энэхүү төв нь бүс нутгийн ард түмнүүдийн аж байдлыг дээшлүүлэх бодлого, стратеги боловсруулах, энэ чиглэлээр хийх судалгааны материал боловсруулж, нийтлүүлэхэд гишүүн орнуудад туслалцаа үзүүлдэг байгууллага юм. Мөн хүн амын өсөлтийн асуудлыг зохицуулах, боловсролын системийг боловсронгуй болгох, эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах болон ер нь нийгмийн хөгжлийн ерөнхий асуудлуудаар гишүүн орнуудад зөвлөлгөө өгч, курс, үзүүлэх сургуулийг зохион байгуулдаг байна. Тус төв үндэсний төвүүдээс явуулж байгаа судалгааны ажилд туслахын зэрэгцээ тэднийг холбогдох мэдээллээр байнга хангадаг.

Ази, Номхон далайн эмэгтэйчүүд ба хөгжлийн төв (Asian and Pacific centre for women and development) 1977 онд нээгдсэн. Анх Иранд байснаа 1979 оны 1 дүгээр сараас Бангкокт шилжиж байрлажээ. Бүс нутгийн эмэгтэйчүүдийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулна. Эмэгтэйчүүдийн амьдралын нөхцөлийг судлах, тэдний мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ олон улсын хурал, зөвлөлгөөн, уулзалт зохион байгуулдаг байна. Төвөөс зохион байгуулах ажлыг НҮБ-ын Хөгжлийн Программ болон бусад олон улсын байгууллагууд, үндэсний Засгийн газрууд санхүүжүүлдэг. Судалгааны ажлын дүнг хэвлэж нийтэлдэг байна.

Ийнхүү Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комиссын дэргэд буюу түүний ивээл дор ажилладаг дээрх байгууллагуудаас гадна бие даасан олон улсын Засгийн газар хоорондын буюу Засгийн газрын бус байгууллагын заримаас товч дурдвал:

Засгийн газар хоорондын байгууллагын нэгэнд Азийн хөгжлийн банк (Asian development bank) орно. Энэ банк Ази, Номхон далайн бүс нутгийн Эдийн засаг, нийгмийн комиссын санаачилгаар байгуулагдсан боловч бие даасан байгууллага юм. Бүс нутгийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагаа, гадаад худалдааг хөгжүүлэх, түүнийг эдийн зас-

гийн бодлоготой уялдуулан зохицуулах, санхүүгийн зээл олгох, техникийн туслалцаа үзүүлэх үүрэгтэй. Манил хотод байрладаг. Банкны санхүүгийн нөөц нь хувь нийлүүлсэн капитал, зээллэгээс бүрддэг ажээ. Азийн хөгжлийн банк нь олон улсын болон үндэсний санхүү-зээлийн байгууллагуудтай төрөл бүрийн барилга, байгууламж барих ажлыг санхүүжүүлэх замаар хамтран ажилладаг байна. Банк Азийн хөгжлийн фонд, Техникийн туслалцаа үзүүлэх тусгай фонд гэсэн 2 үндсэн фондтой юм. Хөгжиж байгаа орнууд банкны гишүүн болсноор олон улсын санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд оролцож, тэдгээрийн зүгээс гаргаж байгаа шийдвэрт өөрийн саналаа тусгуулах, банкнаас хоёр талаар зээл, тусламж авах боломжтой болдог байна.

Засгийн газрын шинж чанартай бус олон улсын байгууллагуудын нэг нь Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны бага хурал (Pacific economic cooperation conference) юм. Уг Бага хурлыг 1980 онд бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны сүлжээг бий болгох зорилгоор байгуулжээ. Бага хурал (тогтсон нарийн бүтэцгүй боловч) бүх гишүүдийн зөвлөлгөөн, байнгын хороо, хэд хэдэн тусгай бүлэг, зохицуулах бүлэг болон бүс нутгийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны үндэсний хороод гэсэн бүтэцтэй юм. Энэ байгууллагын зорилго нь Номхон далайн орнуудын эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг хөгжүүлж, хамтын ажиллагаанд бусад орнууд оролцох боломжийг бүрдүүлэх, Ази, Номхон далайн бүс нутгийн хөгжиж байгаа орнуудад тусламж үзүүлэх хэлбэрийг бий болгоход чиглэж байна. Бага хурлын үйл ажиллагааны үндсэн 2 зарчим байдаг гэж хэлж болох юм. Энэ нь энх тайвныг эрхэмлэж, оролцогч бүх орны эрх ашгийг хамгаалах зарчим юм. Энэ байгууллагад элсэж ороход үндсэндээ чөлөөтэй. Гэвч түүний үйл ажиллагаанд оролцох эрх олж авахын тулд бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох ёстой гэсэн болзол тавигддаг ажээ. Нөгөө нэг болзол нь Бага хуралд элсэхийн тулд тухайн орон өөртөө 3 этгээд бүхий үндэсний хороо байгуулсан байх шаардлагатай байна. Одоогийн байдлаар Бага хурлын үйл ажиллагааг гишүүн орнуудын үндэсний хороод санхүүжүүлж байгаа боловч цаашид Бага хурлын бүх гишүүдээс татвар авч, эдийн засгийн хамтын ажиллагааны судалгааны фондтой болохоор яригдаж байгаа юм байна.

Ази, Номхон далайн бүс нутагт улс төр, эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагуудын зэрэгцээ олон нийтийн шинж чанартай олон улсын байгууллагууд байдаг. Тэд бүс нутагт энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэх, улс түмнүүдийн хооронд найрамдалт харилцааг өргөжүүлэхэд улс төр, эдийн засгийн байгууллагуудаас дутуугүй үүрэг гүйцэтгэдэг байна. Тэдгээрийн тоонд Азийн буддистуудын бага хурал, Азийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, АСЕАН-ы орнуудын сэтгүүлчдийн холбоо, Номхон далайн шинжлэх ухааны холбоо орно. Энэ байгууллагуудын дотроос нэлээд сонирхолтой нь 1920 онд байгуулагдсан Номхон далайн шинжлэх ухааны холбоо (Pacific scientific association) болно. Түүний гишүүнээр ямар ч улс элсэж болох юм. Европ, Ази, Африк, Америк, Австрали тивийн олон орон энэ холбооны гишүүн бөгөөд холбооны гол зорилго нь хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, шинжлэх ухаан, техникийн оновчтой салбарыг хөгжүүлэх, байгалийн нөөц, баялгийг зохистой ашиглахад туслалцаа дэмжлэг үзүүлэх явдал юм. Тус байгууллагын дээд удирдлага нь дөрвөн жилд 1 удаа хуралддаг конгресс (их хурал) бөгөөд их хурлын хооронд үйл ажиллагааг эрдэм шинжилгээний зөвлөл эрхлэн явуулдаг байна. Эрдэм шинжилгээ, судалгааны тодорхой сэдвүүдээр олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, курс,

семинарыг явуулдаг байна.

Манай улсын нийгэм эдийн засгийн бүх салбарт өөрчлөлт, шинэчлэлт явагдаж, зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа өнөө үед бүс нутгийнхаа олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд боломжийн хирээр оролцох нь нэн чухал. Ингэснээр манай орны хувьд бүс нутгийн эдгээр байгууллагуудын хүрээнд явагдаж байгаа олон улсын хөдөлмөрийн хуваарьт оролцох боломж нээгдэх бөгөөд энэ нь Ази, Номхон далайн орнуудтай худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын харилцааг өргөжүүлэн хөгжүүлнэ гэсэн үг болно. Цаашилбал, бүс нутгийн олон улсын байгууллагуудаас хөгжиж байгаа орны хувьд санхүү, эдийн засгийн тусламж авах боломж нэмэгдэнэ.

Иймд бүс нутгийн олон улсын байгууллагуудын үйл ажиллагаа дэг журам, бололцоог нь сайтар судалж, ямар байгууллагатай ямар чиглэлээр хэрхэн хамтран ажиллавал үр ашигтай болох талаар тодорхой баримтлал боловсруулах зэрэг асуудлыг урьдаас бодох нь зүйтэй буй заа.

1. «Дорнодахины судлалын асуудал» № 2 (21), 1989, х. 54--61
2. Дипломатический словарь. , т. I, М., 1984, с. 17
3. Краткий политический словарь. М., 1989, с. 17
4. Economic and Social Commission for Asia and the Pacific in brief, 1989
5. «Олон улсын байгууллагууд» УБ., 1989. х. 8, 67
6. Е. М. Primakov and А. I. Vlasov «What's What in world politics» М., 1987, р. 47
7. Asian development bank: Questions and Answers. 1990. р. 1-3